

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР № 00001107

| | | | |
|--|-------------------------------|---------------|--|
| Огноо: | 2022-06-08 | Дансны дугаар | Дүн /тоогоор/ |
| Төлөгч: | Диспетчерийн үндэсний төв ХХК | Дебит | 8,964,307.21 |
| Төлөгчийн: | Худалдаа Хөгжлийн Банк | 406002860 | |
| Хүлээн авагч: | Аудитын шалгалтын орлого | Кредит | |
| Хүлээн авагчийн: | Төрийн Сан | 100900000601 | |
| Мөнгөний дүн тоогоор (үсгээр) | 8,964,307.21 | | |
| (Найман сая есөн зуун жаран дөрвөн мянга гурван зуун долосон төгрөг 21 мөнгө) | | | ... хоногийн ... хувийн торгууль төгрөг ... мөнгө |
| Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн: | | | Дүн (торгуулийн хамт) |
| Дагалдах баримтын № | Огноо: 2022-06-08 | | **** |
| Төлбөрийн зориулалт (барааны болон ажил үйлчилгээний нэр) | | | Гүйлгээний утга (Төлбөрийн зориулалт) |
| 63/АО150055, АХГ 2022/101НА-СТА-ТӨА актын төлбөр /РД2699877/ | | | |
| Гүйцэтгэх захирал: <i>T. Baimshir</i> Банкнд гүйлгээ хийсэн | | | Төлөх хугацаа |
| Тамга | | | Төлбөрийн ээлж |
| Ерөнхий нягтлан бодогч: <i>[Signature]</i> | | | |
|  | | |  |

Гүйцэтгэх захирал: *T. Baimshir*

Банкинд гүйлгээ хийсэн

... оны ... сарын ...

Ерөнхий нягтлан бодогч: *[Signature]*

(тэмдэг, гарын үсэг)

Төлөх хугацаа

Төлбөрийн ээлж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 өдөр 63/АО/СООСС
АХГ-2022/101/МА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар тогтоол, гүйцэтгэх захирлын 2021 оны 5/98 дугаар тушаалаар бүтэц, сэрэн тоог шинэчлэн баталсан байна. Энэхүү тушаалаар батлаагүй албан тушаалыг 4 ажилтнаар хавсран гүйцэтгүүлж, дээд байгууллагын шийдвэргүй 8,964,307.21 төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3 "... төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх ..." гэсэн заалттай нийцээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/15 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Батлагдаагүй албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж олгосон 8,964,307.21 /найман сая есөн зуун жаран дөрвөн мянга гурван зуун долоон төгрөг хорин нэгэн мөнгө/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж, үндэсний аудитын газрын Төрийн сан банк дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Балжинням, нягтлан бодогч Т.Бямбажав нарт даалгав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

[Handwritten signature]

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

[Handwritten signature]

Н.ДЭЛГЭРМАА